ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/100/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот

2022 он


Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112 Цахим хаяг:khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Туяа
Утас: 99028942 Цахим хаяг:tuyan@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Contents

Contents ..... 1
**1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3**
**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4**
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4**
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6**
**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8**
**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 9**
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11**
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 13**
**3. Аудитын тайлан ..... 14**
3.1 Ерөнхий зүйл ..... 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14
3.4 Материаллаг байдал ..... 15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 16
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 17
3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17
**4. Аудитын илрүүлэлт ..... 17**
4.2 Албан шаардлага ..... 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 18
**6. Аудитын тайлангийн хавсралт ..... 18**
**6.1. Албан шаардлага 2021.03.07 № ХЭА-2022/100/НА-СТА-ТШЗ .....**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.04 № 234

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БИНДЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ӨНӨБОЛД ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

02303056Э

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,123,111,695.40** | **213,094,954.55** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 1,052,000.00 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 1,052,000.00 |
| 3121 | **Төгрөг** | - | 1,052,000.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 1,052,000.00 |
| 33 | **АВЛАГА** | 4,123,000.00 | 8,066,822.15 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 74,767.15 |
| 335 | **Бусад авлага** | 4,123,000.00 | 7,992,055.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 4,123,000.00 | 7,992,055.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 4,118,988,695.40 | 203,976,132.40 |
| 351 | **Түүхий эд материал** | - | 3,228,300.00 |
| 35130 | Эм боох материал | - | 3,228,300.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 4,115,273,695.40 | 196,047,832.40 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,122,110.00 | 7,533,210.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 92,806,877.40 | 178,891,137.40 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,680,000.00 | 279,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,280,230.00 | 1,639,050.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 8,879,625.00 | 7,705,435.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,000,504,853.00 | - |
| 35600 | Мал амьтад | 3,715,000.00 | 4,700,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,069,123,870.12** | **12,591,791,200.06** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,069,123,870.12 | 12,591,791,200.06 |
| 392 | **Биет хөрөнгө** | 931,131,870.12 | 12,453,799,200.06 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 956,751,894.47 | 12,448,326,764.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (304,270,401.47) | (364,727,221.43) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 94,653,800.00 | 153,584,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (92,691,050.00) | (28,755,111.91) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 312,529,146.31 | 316,448,073.51 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (202,807,028.47) | (225,174,534.63) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,245,052.08 | 49,022,862.08 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (32,573,570.62) | (35,127,666.02) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 199,328,352.40 | 201,922,352.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (45,034,324.58) | (61,723,118.41) |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 137,992,000.00 | 137,992,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 137,992,000.00 | 137,992,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,192,235,565.52** | **12,804,886,154.61** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,260,367.77** | **-** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5,260,367.77 | - |
| 413 | **Өглөг** | 5,260,367.77 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 3,623,267.77 | - |
| 4136 | **Бусад өглөг** | 1,637,100.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,637,100.00 | - |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,048,983,197.75** | **12,804,886,154.61** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,048,983,197.75 | 12,804,886,154.61 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 395,133,092.78 | 533,125,092.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 395,133,092.78 | 395,133,092.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,482,439,820.06 | 12,100,350,776.92 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,482,439,820.06 | 4,482,439,820.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 7,617,910,956.86 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 171,410,284.91 | 171,410,284.91 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,054,243,565.52** | **12,804,886,154.61** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **615,665,379.00** | **12,144,190,469.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **154,034,711.00** | **11,545,708,670.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 154,034,711.00 | 11,545,708,670.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 154,034,711.00 | 11,545,708,670.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 198,000.00 | 3,523,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 153,836,711.00 | 11,542,185,670.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **461,630,668.00** | **598,481,799.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 20,493,368.00 | 94,702,099.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,430,000.00 | 165,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,155,358.00 | 76,339,369.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,908,010.00 | 18,197,730.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 441,137,300.00 | 503,779,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 441,137,300.00 | 503,779,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **548,199,722.17** | **4,526,279,512.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **548,199,722.17** | **4,526,279,512.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 490,028,610.61 | 4,519,261,791.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 238,299,035.70 | 234,683,951.00 |
| 210101 | Үндсэн цалин | 238,153,317.70 | 227,981,247.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 145,718.00 | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 6,702,704.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,069,788.00 | 31,581,357.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,285,518.00 | 22,263,876.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,147,244.00 | 2,316,745.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,871,126.00 | 1,877,712.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 768,761.00 | 792,429.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,997,139.00 | 4,330,592.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25,031,427.66 | 41,009,387.61 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,018,227.66 | 27,075,387.61 |
| 210302 | Түлш, халаалт | 16,893,200.00 | 13,934,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 120,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,068,152.85 | 21,321,840.02 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,968,140.00 | 1,058,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,853,565.00 | 15,774,172.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,212,447.85 | 2,716,047.42 |
| 210404 | Ном, хэвлэл | 34,000.00 | 101,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,671,720.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,418,900.00 | 272,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 775,500.00 | 80,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 643,400.00 | 192,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,261,750.00 | 13,996,390.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,261,750.00 | 13,996,390.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,623,000.00 | 4,488,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,623,000.00 | 4,488,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 20,132,353.96 | 16,738,023.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,347,521.96 | 10,638,484.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 461,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 410,100.00 | 156,825.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 197,100.00 | 250,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 798,632.00 | 1,031,214.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 130,124,202.44 | 4,155,170,843.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,499,120.00 | 4,040,533,903.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 55,000.00 | 225,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 99,570,082.44 | 114,411,940.06 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 58,171,111.56 | 7,017,720.44 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,167,600.00 | 5,591,100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,038,600.00 | 2,681,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,129,000.00 | 2,910,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 30,003,511.56 | 1,426,620.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 30,003,511.56 | 1,426,620.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **67,465,656.83** | **7,617,910,956.86** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **67,465,656.83** | **7,617,910,956.86** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 533,125,092.78 | 171,410,284.91 | 4,482,439,820.06 | 5,186,975,197.75 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **533,125,092.78** | **171,410,284.91** | **4,482,439,820.06** | **5,186,975,197.75** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **533,125,092.78** | **171,410,284.91** | **4,482,439,820.06** | **5,186,975,197.75** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **533,125,092.78** | **171,410,284.91** | **4,482,439,820.06** | **5,186,975,197.75** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **533,125,092.78** | **171,410,284.91** | **4,482,439,820.06** | **5,186,975,197.75** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 7,617,910,956.86 | 7,617,910,956.86 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **533,125,092.78** | **171,410,284.91** | **12,100,350,776.92** | **12,804,886,154.61** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **463,604,728.00** | **606,127,799.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **198,000.00** | **3,523,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 198,000.00 | 3,523,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 198,000.00 | 3,523,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 198,000.00 | 3,523,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **463,406,728.00** | **602,604,799.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,269,428.00 | 98,825,099.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,430,000.00 | 165,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,155,358.00 | 76,339,369.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,684,070.00 | 22,320,730.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 441,137,300.00 | 503,779,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 441,137,300.00 | 503,779,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **463,604,728.00** | **460,523,399.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **463,604,728.00** | **460,523,399.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **401,310,616.44** | **445,443,623.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 234,056,349.93 | 237,932,930.77 |
| 210101 | Үндсэн цалин | 158,448,615.93 | 158,535,825.80 |
| 210102 | Нэмэгдэл | 52,443,147.00 | 50,825,474.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,290,844.00 | 3,861,669.80 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,873,743.00 | 24,709,960.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,841,271.00 | 31,656,124.16 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,578,060.00 | 22,389,086.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,321,336.00 | 2,316,745.03 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,835,696.00 | 1,848,300.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 464,007.00 | 468,461.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,642,172.00 | 4,633,530.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,113,627.66 | 40,539,387.61 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,018,227.66 | 8,368,587.61 |
| 210302 | Түлш, халаалт | 19,615,400.00 | 32,170,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 480,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,476,552.85 | 21,150,836.02 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,839,300.00 | 2,828,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,618,805.00 | 12,304,368.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,054,447.85 | 2,459,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 17,000.00 | 160,267.42 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 947,000.00 | 3,399,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,596,300.00 | 2,675,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 848,500.00 | 585,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 747,800.00 | 2,090,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 26,314,750.00 | 16,130,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 4,450,000.00 |
| 210602 | Тавилга | 10,980,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 15,334,750.00 | 11,680,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,623,000.00 | 4,488,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,623,000.00 | 4,488,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,139,645.00 | 20,810,235.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,638,613.00 | 14,426,896.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 461,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 126,300.00 | 440,625.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 197,100.00 | 250,100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 798,632.00 | 1,031,214.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,149,120.00 | 70,060,010.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,558,870.00 | 69,253,810.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 590,250.00 | 806,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **62,294,111.56** | **15,079,775.44** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,167,600.00 | 5,661,100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,038,600.00 | 2,681,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,129,000.00 | 2,980,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 34,126,511.56 | 9,418,675.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,507,966.56 | 1,426,620.44 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,618,545.00 | 7,992,055.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **145,604,400.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,980,000.00** | **144,552,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,980,000.00** | **144,552,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,980,000.00 | 144,552,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,980,000.00 | 144,552,400.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(10,980,000.00)** | **(144,552,400.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (10,980,000.00) | 1,052,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 1,052,000.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 505,579,700.00 | 503,586,079.56 | 1,993,620.44 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 446,279,700.00 | 444,286,079.56 | 1,993,620.44 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 440,618,600.00 | 438,624,979.56 | 1,993,620.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 235,795,400.00 | 235,380,630.77 | 414,769.23 |
| 210101 | Үндсэн цалин | 160,293,700.00 | 158,535,825.80 | 1,757,874.20 |
| 210102 | Нэмэгдэл | 49,422,200.00 | 50,825,474.40 | (1,403,274.40) |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,780,000.00 | 3,861,669.80 | (81,669.80) |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 22,299,500.00 | 22,157,660.77 | 141,839.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,169,900.00 | 31,329,826.16 | 840,073.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,638,000.00 | 22,062,788.84 | 575,211.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,383,000.00 | 2,316,745.03 | 66,254.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,906,400.00 | 1,848,300.45 | 58,099.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 476,600.00 | 468,461.78 | 8,138.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,765,900.00 | 4,633,530.06 | 132,369.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,589,500.00 | 40,539,387.61 | 50,112.39 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,418,700.00 | 8,368,587.61 | 50,112.39 |
| 210302 | Түлш, халаалт | 32,170,800.00 | 32,170,800.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,002,200.00 | 19,980,436.02 | 21,763.98 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,828,000.00 | 2,828,000.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,350,000.00 | 11,348,968.60 | 1,031.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,244,000.00 | 2,244,000.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 181,000.00 | 160,267.42 | 20,732.58 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,399,200.00 | 3,399,200.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **2,675,500.00** | **2,675,500.00** | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 585,500.00 | 585,500.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,090,000.00 | 2,090,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **28,960,600.00** | **28,960,000.00** | **600.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,450,000.00 | 11,450,000.00 | - |
| 210602 | Тавилга | 5,830,000.00 | 5,829,400.00 | 600.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,680,600.00 | 11,680,600.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,490,300.00 | 4,488,000.00 | 2,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,490,300.00 | 4,488,000.00 | 2,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,696,700.00 | 15,282,749.00 | 413,951.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,900,000.00 | 8,899,410.00 | 590.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 461,400.00 | 461,400.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 503,500.00 | 440,625.00 | 62,875.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 252,000.00 | 250,100.00 | 1,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 86,000.00 | - | 86,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,200,000.00 | 4,200,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 1,293,800.00 | 1,031,214.00 | 262,586.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 60,238,500.00 | 59,988,450.00 | 250,050.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,432,000.00 | 59,182,250.00 | 249,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 806,500.00 | 806,200.00 | 300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,661,100.00 | 5,661,100.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,661,100.00 | 5,661,100.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 2,681,100.00 | 2,681,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,980,000.00 | 2,980,000.00 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **59,300,000.00** | **59,300,000.00** | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 59,300,000.00 | 59,300,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 59,300,000.00 | 59,300,000.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 505,579,700.00 | 503,586,079.56 | 1,993,620.44 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 503,779,700.00 | 502,353,079.56 | 1,426,620.44 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 503,779,700.00 | 502,353,079.56 | 1,426,620.44 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,800,000.00 | 1,233,000.00 | 567,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,800,000.00 | 1,233,000.00 | 567,000.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 6 | 6 | |
| 610001 | Төсвийн байгууллага | 6 | 6 | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24 | 24 | |
| 620001 | Удирдах ажилтан | 8 | 8 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 6 | 6 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **24.00** | **24.00** | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 7.00 | 7.00 | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6.00 | 6.00 | |
| 650010 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7.00 | 7.00 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **98,825,099.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **20,833,044.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 20,833,044.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,552,300.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,552,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 326,298.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 326,298.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,170,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 955,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 215,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,527,486.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,527,486.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,256,560.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,256,560.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **7,992,055.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 7,992,055.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **70,000,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 70,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 70,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **98,825,099.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **98,825,099.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 165,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 76,339,369.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,320,730.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргийг “харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах,...” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 547.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 12,804.9 сая төгрөг болж, өмнөх оноос 7,612.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 1.0 | 1.0 |
| Авлага | 4.1 | 8.1 | 4.0 |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 4,119.0 | 204.0 | (3,915.0) |
| Үндсэн хөрөнгө | 1,069.1 | 12,591.8 | 11,522.7 |
| **Нийт хөрөнгө** | **5,192.2** | **12,804.9** | **7,612.7** |
| Өр төлбөр | 5.3 | | (5.3) |
| Засгийн газрын оруулсан капитал | 533.1 | 533.1 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 4,482.4 | 12,100.4 | 7,618.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 171.4 | 171.4 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **5,192.2** | **12,804.9** | **7,612.7** |

Мөнгөн хөрөнгийн дансанд ахмадын сангийн 1.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 8.1 сая төгрөг болж 4.0 сая төгрөгөөр өссөн нь нэмэлт дансны төвлөрүүлсэн үлдэгдлийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 204.0 сая төгрөг болж 3,915.0 сая төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалд бүртгэлтэй байсан жишиг сумын байгууламжийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,591.8 сая төгрөг болж 11,522.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,399.3 сая төгрөгийн Онон голын бетонон гүүр, аймгийн хөрөнгө оруулалтаар 146.0 сая төгрөгийн хөрөнгийг, хандиваар барьсан 35.0 сая төгрөгийн багийн төвийн барилгыг, бараа материалын данснаас 4,000.5 сая төгрөгийн жишиг сумын байгууламжуудыг, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 73.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, 145.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 9,153.9 сая болж 4,671.5 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 11,528.5 сая төгрөгөөр буюу 19.7 дахин өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 11,388.3 сая төгрөгөөр, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 69.2 сая төгрөгөөр, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9.3 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 62.6 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 3,978.1 сая төгрөгөөр буюу 8.2 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс байр ашиглалттай холбоотой зардал 16.0 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 2.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 4,025.0 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 529.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 23.5 сая төгрөгөөр бууруулан 505.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 505.6 сая төгрөгийн төсөв батлсныг орон нутгийн төсвөөс 503.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 503.8 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1.2 сая, нийт 503.6.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 804.7 сая төгрөгийг зарцуулж 1.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 0.2 сая, дээд шатны төсөв захирагчаас 76.3 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 22.3 сая нийт 98.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны сайтад оруулбал зохих мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн, үнэн зөв мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

## 3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## 3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдлийг тулгахаар шийдвэрлэв.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүллээ.

### 4.2 Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй 9.3 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 5.6 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

2. Нэмэлт дансанд Хурх голын гүүрний хураамжийн орлого 3.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 23.9.3. "хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого" заалтад нийцээгүй байна.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газар | 2 | 9.3 | | | | | 2 | 9.3 | | |
| **Дүн** | | **2** | **9.3** | | | | | **2** | **9.3** | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газар | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | |
| **Нийт дүн** | | **2** | **9.3** | | | | | **2** | **9.3** | | |

## 6. Аудитын тайлангийн хавсралт

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 дугаар сарын 04 Дугаар 159/A2370447 Чингис хот
ХЭА 2022/100/НА ЕТА-ТНЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 5.6 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д **"**хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал**"** заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Өнөболд, нягтлан бодогч Х.Гангансувд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082

023040083

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 04 Дугаар 158/А2370447 ХЭА 2022/100/НА Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн дансанд Хурх голын гүүрний хураамжийн орлого 3,698.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.9 дэх "Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.9.3 "хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого" заалтад нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын төсвийн орлогод төвлөрүүлэх орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлдэг зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Өнөболд, нягтлан бодогч Х.Гангансувд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР Н.ТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас:

023040590